

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ
БОДЛОГО, ҮНЭЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА

Г. ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“ГОВЬ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



[Signature] С.АЛИМАА

**“ГОВЬ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-ИЙН ӨМНӨГОВЬ
АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ
“НҮҮРС БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ-2026**

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР:5339303

ХЯНАСАН:

ХБОБХГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН:

Н.ЭРДЭНЭЧИМЭГ

БОЛОВСРУУЛСАН:

“ГОВЬ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ” ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖЕР:

[Signature]

А.ОЮУНТУЯА

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Төслийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2. Төслийн байршил, төсөл хэрэгжиж буй орчны тойм зураг	2
1.3. Нүүрс баяжуулах үйлдвэр	4
1.4. Төслийн хүчин чадал.....	4
БҮЛЭГ 2. ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	8
БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	10
БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	11
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ...	18
БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	23
БҮЛЭГ 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ 12. ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	26

Хүснэгтэнд мэдээлэл

Хүснэгт 1 Төслийн талбайн солбилцол, УТМ-48.....	3
Хүснэгт 2 Хүчин чадал.....	5
Хүснэгт 3 Нөлөөллийн зэрэглэл.....	8
Хүснэгт 4 Нөлөөллийн зэрэглэлийн өнгөний шатлал.....	8
Хүснэгт 5 Зэрэглэлийн тодорхойлолт	8
Хүснэгт 6 Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл	9
Хүснэгт 7 Сөрөн нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 8 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	17
Хүснэгт 9 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 10 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	20
Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	23
Хүснэгт 12 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	25
Хүснэгт 13 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	26
Хүснэгт 14 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал.....	28

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ТӨСЛИЙН НЭР:

Нүүрс баяжуулах үйлдвэр

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН НЭР:

“Говь Ресурс Девелопмент” ХХК

Регистр:5333903

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ХАЯГ:

Улаанбаатар хот, Олимпын гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, New horizons, 10-р давхар 1001 тоот

Утас: 80776600

1.1. Төслийн ерөнхий мэдээлэл

“Говь Ресурс Девелопмент” ХХК нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Эрдэнэс таван толгой, Таван толгой, Ухаа худаг, Баруун нарангийн нүүрсний орд болон нүүрс баяжуулах үйлдвэрүүдээс түүхий эдээ татах бүрэн боломжтой юм. Төсөл хэрэгжүүлэгч нь 2022 оноос өнөөг хүрэл “Энержи Ресурс” ХХК -ийн Ухаа худгийн нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлыг баяжуулж өгөх гэрээнд үндэслэн хуучин хаягдлын даланд хураагдсан хаягдлаас түүхий эдээ ханган хэвийн тогтвортой ажиллаж байгаа ба 2026 онд нүүрс баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийг барьж байгуулан хүчин чадлыг өсгөн үйл ажиллагааны хүрээгээ тэлэн ажиллуулахаар төлөвлөөд байна..

1.2. Төслийн байршил, төсөл хэрэгжиж буй орчны тойм зураг


“Говь ресурс девелопмент” ХХК-ийн “Нүүрс баяжуулах үйлдвэр” төслийн талбайн ойр орчмын газар нутаг нь Монгол орны физик газарзүйн мужлалаар хуурай уур амьсгалтай говийн бүслүүрт хамаарагддаг. Далайн түвшнээс дээш 1500-1600 м өндөрт өргөгдсөн, өндөршлийн ялгаа харьцангуй бага ажиглагдах нам уулс, толгодоор хүрээлэгдсэн байна.

Төсөл хэрэгжих талбай нь Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэрт нийслэл Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 540 км, аймгийн төв Даланзадгад сумаас зүүн зүгт 90 км, Монгол-БНХАУ-ын хилийн зурвасаас 220 гаруй км, Цогтцэций сумын төвөөс урд зүгт 8 км, Ухаа худаг, Таван Толгойн нүүрсний орд газраас хойд зүгт 4-5 км орчим зайд оршино.

Хүснэгт 1 Төслийн талбайн солбилцол, UTM-48

Координат дугаар	X	Y
1	105 ⁰ 35' 31.75"	43 ⁰ 40' 17.52"
2	105 ⁰ 35' 37.20"	43 ⁰ 40' 22.67"
3	105 ⁰ 35' 51.36"	43 ⁰ 40' 14.78"
4	105 ⁰ 35' 45.91"	43 ⁰ 40' 09.63"

Зураг 1 Төсөл хэрэгжиж буй газрын байршил



1.3. Нүүрс баяжуулах үйлдвэр

Нүүрс баяжуулах үйлдвэр газарзүйн байршлын хувьд Ухаа худаг, Баруун наран, Эрдэнэс таван толгой, Таван толгойн нүүрсний уурхайтай ойрхон байрлаж байгаа тул нүүрсний тээвэрлэлт хийх зай бага байгаа нь тээврийн зардалд хэмнэлттэй төдийгүй эргэлтийн давтамж олон байгаа нь үйлдвэр тэжээлийн тасалдалгүй жигд ажиллах гол хүчин зүйл болж байна. Нүүрс баяжуулах үйлдвэр 2013 онд баригдаж ашиглалтын 10 дахь жил рүү орсон тул төсөл хэрэгжүүлэгч “Говь Ресурс Девелопмент” ХХК нь үйлдвэрийн элэгдэлд орсон тоног төхөөрөмжийг шинэчлэх, засвар үйлчилгээ хийх, мөн тоног төхөөрөмжийн бэлэн байдал, үйлдвэрийг тасралтгүй ажиллуулах боломжийг илэрхийлэн БНХАУ -аас гадаад инженер, техникийн ажилчдыг ажиллуулж, шинэчлэл сайжруулалтын хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэн ажиллаж байгаа билээ.

Уг нүүрс баяжуулах үйлдвэр нь жилийн 720 мян.тн -ын хүчин чадалтай ба гравитаци, флотацийн технологиор нүүрс баяжуулж байна. Нүүрс баяжуулах үйлдвэр нь нүүрс болон хаягдал тээвэрлэлт, нүүрс буулгах талбай, нүүрс тэжээх хэсэг, баяжуулалтын хэсэг /гравитаци, флотаци/, усгүйжүүлэх хэсэг, ачилт, буулгалт гэсэн үндсэн хэсгүүдээс тогтоно.

1.4. Төслийн хүчин чадал

Үйлдвэрийн одоогийн хүчин чадал

Төсөл хэрэгжүүлэгч “Говь Ресурс Девелопмент” ХХК-ийн одоогийн нүүрс баяжуулах үйлдвэр нь жилийн 720 мян. тн хүчин чадалтай ба 2024 онд нүүрс баяжуулах үйлдвэрт өргөтгөл хийж хүчин чадлыг 500.0 мян. тн -оор нэмэгдүүлэн нийт 1.22 сая.тн нүүрс баяжуулах хүчин чадалтай болгохоор төлөвлөсөн. Нүүрс баяжуулах үйлдвэрийн түүхий эдийн чанар, технологийн схем, технологийн тооцоолол, нүүрсний гарц, бүтээгдэхүүний чанар зэргийг 2023 онд “АМБ лаб” ХХК -ийн лабораторид гүйцэтгэсэн байна.

Үйлдвэрийн ажлын горим

Нүүрс баяжуулах үйлдвэрийн ажиллах горимыг тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, урсгал засвар, цаг агаарын нөхцөл, баяр ёслолын өдөр зэргийг тооцож жилд 272 хоног ажиллахаар төлөвлөсөн ба баяжуулах үйлдвэрийн цаг ашиглалт болон тоног төхөөрөмжийн бэлэн байдлын коэффициентийг тооцож төлөвлөсөн болно.

Баяжуулах үйлдвэрийн технологийн горимыг одоогийн байгаа нүүрс баяжуулах үйлдвэр болох 720.0 мян. тн, мөн өргөтгөл үйлдвэрийн 500.0 мян. тн хүчин чадалд тулгуурлан тооцсон.

Хүснэгт 2 Хүчин чадал

Д/д	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Одоогийн үйлдвэр	Өргөтгөл үйлдвэр
			1-5 жилд	
1	Жилийн хуанлийн өдрийн тоо	-	365	365
2	Жилийн хуанлийн сар	-	12	12
3	Жилийн хуанлийн хугацаа	цаг	8760	8760
4	Өдрийн хуанлийн хугацаа	цаг	24	24
5	Жилийн баяр ёслолын өдрүүд	хоног	3	3
6	Жилийн засвар үйлчилгээний хоног	хоног	90	90
7	Өдөрт ажиллах боломжит цаг	цаг	22	22
8	Жилд ажиллах бодит хоног	хоног	272	272
9	Жилд ажиллах бодит цаг	цаг	6528	6528
10	Үйлдвэрийн цаг ашиглалт	%	90	90
11	Техникийн бэлэн байдлын коэффициент	%	80	85
12	Жилд ажиллах бодит цаг	цаг	4805	4993
13	Цагийн хүчин чадал	тн/цаг	150	100
14	Хоногийн хүчин чадал	тн/хоног	3597	2403
15	Жилийн хүчин чадал	тн/жил	720,000.0	500,000.0

**БҮЛЭГ 2. ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ
БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ**

Физик газарзүй: Цогтцэций сум нь Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотоос зүүн зүгт 90км, Улаанбаатараас 540км-т байрлана. Ц Цогтцэций сум нь хойд өргөргийн 43°42'84.0", дорнод уртрагийн 105°34'76.6"-ийн солбилцолд оршдог. Цэций салхин цахилгаан станц нь сумын төвөөс зүүн урд зүгт 20 орчим км-т хойд өргөргийн 43°34'03.8", дорнод уртрагийн 105°37'05.1" солбилцолд оршино. Тус станцын нийт төслийн талбай нь 700 га байна.

Цаг уур, уур амьсгалын онцлог: Сүүлийн 45 жилд аймгийн хэмжээнд VII сарын дундаж температур бараг 3.2°C-аар дулаарсан, энэ нь 1990-ээд оны дунд үеэс хойш жил бүр эрчимжиж байгаагаас харагдана.

Өмнөговь аймагт агаарын хоногийн дундаж температур 10 сарын сүүлээс 0о градусаас доош орж хүйтрэх ба 3 сарын 25-аас дулаарч эхэлдэг буюу 215-240 хоног нь 0о градусаас дээш дулаан байдаг байна.

Агаарын температурын жилийн явцыг харахад 1 дүгээр сард хамгийн хүйтэн, 7 дугаар сард хамгийн дулаан байдаг Монгол орны уур амьсгалын ерөнхий зүй тогтол давтагдаж байна.

Салхины үзүүлэлт: Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, агаарын даралт, тухайн нутгийн физик газар зүйн нөхцөлөөс ихээхэн шалтгаалдаг. Монгол орны тал хээр, говь, цөлийн бүс нь салхи ихтэй байдаг. Салхины жилийн дундаж хурд энэ бүс нутагт 4-6 м/с байна. Энэ бүс нутагт жилдээ 30-100 өдөр, Монгол элсний өмнөд захад жилдээ 120 өдөр шороо хийснэ. Өмнөговь аймгийн нийт сумдад жилд 19-55 хоног шороон шуурга ажиглагддаг байна.

Агаарын чанар: Цэций салхин цахилгаан станцын талбайд хийсэн мониторингуудын үр дүнгээс харахад нарийн болон том ширхэгт тоосонцор, нийт тоосонцор мөн SO₂, NO₂-ын хэмжээ төслийн аль ч талбайд стандартад заасан хэмжээнээс даваагүй хэвийн хэмжээнд байна. Тоосонцрын хэмжилтийн үр дүнг мониторингийн цэгүүд болох Кемпийн хашаа, зам дагуух цэгүүдийг хийн ялгарлын хэмжээгээр харьцуулж харахад Кемпийн хашаан дотор илүү бохирдолтой байгаа юм. Харин шуугианы хэмжээ 2018-2019 онд MNS 4685:2016 стандартад заасан хүлцэх хэмжээнээс хэтрээд байсан ч 2020 оноос хойш буурч хүлцэх хэмжээний босго утгаас багассан байна.

Хөрсөн бүрхэвч: Төслийн талбай орчимд Монгол орны хөрсний ангиллаар говийн Бор хэв шинжид багтах ердийн Бор хөрс зонхилон тархсан байна. Энэхүү хөрс нь ерөнхий үржил шимийн түвшин багатай, шимт үе давхарга нь нимгэн (2-15 см), маш хэврэг бутрамтгай бүтэцтэй буюу механик нөлөөлөлд амархан өртөж эвдэрч талхлагддаг, байгалийн аясаараа нөхөн чадамж муутай байдаг онцлогтой.

Ургамлан нөмрөг: Өмнөговь аймаг Цогтцэций сумын нутаг нь Монгол орны ургамал-газарзүйн тойргоор Дорноговийн цөлөрхөг хээрийн тойрогт багтдаг. Уг тойрогт Говь-Алтайн нурууны зүүн шувтаргын уулсын араар, дорно зүгт ухаа гүвээрхэг, тэгш талархаг гадаргатай Дорноговь, Дундговь аймгийн өмнөд, Өмнөговь аймгийн зүүн ба хойд хэсгийг хамаарна. Нийт 480 зүйлтэй ба жинхэнэ говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрдсэн ургамлын аймагтай. Зөвхөн тухайн тойрогт тохиолдох 9 зүйл ургамал бий.

Амьтны аймаг: 2021 оны 7 сарын судалгааны явцад 2 зүйл том хөхтөн амьтан болох Аргал (3 бодгаль), Цагаан зээр (184 бодгаль) тус тус бүртгэсэн. Энэхүү судалгаагаар 12 зүйлийн 58 бодгаль шувууд мөн тэмдэглэсэн байна. Төслийн талбай орчимд буюу олон улсын улаан дансны ангиллаар ховордож болзошгүй зэрэгт хамаарах Нөмрөг тас, эмзэг ангилалд

хамаарах Зээрд шонхор, устаж болзошгүй ангилалд хамаарах Идлэг шонхор бүртгэгдсэн байна.

Түүх соёлын өв: Нүүрс баяжуулах үйлдвэрийн талбайд түүх соёлын өв бүртгэгдээгүй байна. Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нутгаар дайран өнгөрөх "Нүүрсний зам" ХХК-ийн шинээр тавих гэж буй хатуу хучилттай замын трассын дагуу 2010 оны 4 дүгээр сарын 1- ээс 4 дүгээр сарын 10-ны хооронд 10 хоногийн хугацаанд хийж нийт хэлбэрт булш 2, тахилын байгууламж 1, чулуун байгууламж 3 нийт 6 дурсгалд малтан судалжээ. Судалгааны багт Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин нарын судлаачид ажиллажээ.

Нийгэм, эдийн засаг: Өмнөговь аймаг нь 165.4 мянган ам дөрвөлжин км нутагтай, 71.5 мянган хүн амтай бөгөөд Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, Алтайн уулархаг мужид багтдаг. Нийт хүн ам 6680, хөдөлгөөнт хүн ам 16100, өрхийн тоо 2315-д хүрсэн байна.

Цогтцэций сумын төвд хүн эмнэлэг, 12 жилийн сургууль, цэцэрлэг, шуудан холбоо болон Голомт, Хадгаламж, Хаан банкны салбарууд, ШТС, зочид буудал, эмийн сан, дэлгүүр зэрэг үйлчилгээний байгууллагууд үйл ажиллагаагаа явуулдаг ба сумын хэмжээнд 288 аж ахуй нэгж, жижиг бизнес эрхлэгч 1290 иргэн үйл ажиллагаагаа явуулж байна. Худалдаа үйлчилгээний газрууд жилээс жилд өсөн нэмэгдэж байна. Тухайлбал: Эмийн сан-5, хүнсний үйлдвэрлэлийн тоо-10, зочид буудал-29, хүнсний дэлгүүр-36, супермаркет-10, хүнсний бөөний төв-5, нийтийн хоолны газар-37 болж нэмэгдсэн байна. Хүн амын дийлэнх нь халх үндэстэн бөгөөд хүн ам суурьшилт багатай байсан боловч сүүлийн жилүүдэд хүн ам огцом өсөх хандлага ажиглагдаж байна.

Хүн амын дийлэнх нь мал аж ахуй голлон эрхэлдэг. Цогтцэций сум нь чулуун нүүрс, гөлтгөнө, галд тэсвэртэй шавар, алт, зэс, хужир зэрэг эрдэс баялгаа хөрсөн дороо агуулсанаас гадна эдийн засгийн голлох салбар нь мал аж ахуй бөгөөд сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж түүнийг даган сум орон нутагт дэд бүтэц хөгжиж, хөгжил цэцэглэлтийн шинэ эрин үетэй зэрэгцэн хөгжих боломж бүрдсэн нутаг юм.

БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нүүрс баяжуулах үйлдвэр төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг БОННУ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- Нөлөөллийн эх үүсвэрүүд /гол асуудлууд/ болон нөлөөллийн тухай
- Үнэлгээний орон зайн цар хүрээ, техникийн болон цаг хугацааны хамрах хүрээний тодорхойлолт
- Төслийн үргэлжлэх бүхий л хугацааны туршид үүсэж болзошгүй нөлөөллийн тодорхойлолт болон сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.

Хүснэгт 3 Нөлөөллийн зэрэглэл

Нөлөөллийн зэрэглэл			
Магадлал	Магадгүй	Болзошгүй	Боломжтой
Цар хүрээ			
Маш бага	Маш бага	Маш бага	бага
Бага	Маш бага	Бага	Бага
Дунд	Бага	Дунд	Дунд

Хүснэгт 4 Нөлөөллийн зэрэглэлийн өнгөний шатлал

Зэрэглэлийн өнгөний шатлал	
Сөрөг нөлөөлөл	Эерэг нөлөөлөл
Маш бага	Маш бага
Бага	Бага
Дунд	Дунд
Их	Их

Хүснэгт 5 Зэрэглэлийн тодорхойлолт

Зэрэглэлийн тодорхойлолт	
Маш бага	Тодорхой үйл ажиллагаанаас байгалийн нөөц болон хүлээн авагч ямар ч нөлөөлөлд өртөхөөргүй маш бага хэмжээний нөлөөллийн зэрэглэл. Эсвэл таамаглаж буй нөлөө нь “маш бага”, “үл мэдэгдэх”, “ажиглагдахгүй” нөлөөлөл.
Бага	Нөлөө үүсэх боловч түүний хэмжээ нэлээн бага бөгөөд нөлөөлөл бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн ч бай, хэрэгжүүлээгүй байсан ч стандартын түвшинд байна. Хүлээн авагчид үзүүлэх нөлөөлөл бага.
Дунд	Стандартын түвшинд байна. Нөлөөллийг хамгийн бага боломжтой түвшинд хүргэж бууруулах боломжтой. Гэхдээ энэ нь “Дунд”-аас “бага” нөлөөлөлд хүргэнэ гэсэн ойлголт биш хэдий ч нөлөөлөл бууруулах арга хэмжээг үр дүнтэй, үр ашигтай хэрэгжүүлэх боломжтой

Их	Стандартын түвшнээс хэтэрч магадгүй ба өндөр ач холбогдолтой/мэдрэмтгий нөөц/хүлээн авагч их хэмжээний нөлөөлөлд өртөнө. БОННУ-ний зорилго нь Төслөөс үлдэгдэл нөлөөлөл гаргахгүй байх, удаан хугацаанд үргэлжлэх, том газар нутагт илрэх нөлөөлөл үүсгэхгүй байхад чиглэнэ. Нөлөөлөл бууруулах бүх боломжит арга хэмжээ авсан ч зарим томоохон нөлөөлөл үлдэж болзошгүй. Бүтээн байгуулалтын нөлөөлөл үүнд орно. Төслийн талаар шийдвэр гаргахад эдгээр сөрөг хүчин зүйлийг хөдөлмөр эрхлэлт зэрэг эерэг хүчин зүйлтэй харьцуулах нь зохицуулагч, оролцогч талуудын үүрэг юм.
----	--

Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүр дээр тооцсон ба нийт 55 болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон. Үүнээс 12 буюу 52.2 % нь бага, 10 буюу 43.5 % нь дунд, 1 буюу 4.3 % нь их гэсэн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Үүнээс үзэхэд төслөөс байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл нь багаас дунд зэрэг байна (Хүснэгт 2-19). Уг БОННУ-ний тайланд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон БОМТ-нд тусгасан арга хэмжээг даган мөрдөж ажилласан тохиолдолд байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зохих түвшинд барих боломжтой байна.

Хүснэгт 6 Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг	Нөлөөллийн үнэлгээ			Нийт
	бага	дунд	их	
Агаарын чанар	1	3	-	4
Хөрсөн бүрхэвч	3	2	1	6
Усан орчин	4	2	-	6
Ургамалан нөмрөг, амьтны аймаг	3	2	-	5
Нийт (тоогоор)	11	9	1	21
Нийт (%)	52.5%	42.6%	4.8%	100%

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой.

“Говь ресурс девелопмент” ХХК нь Монгол улсын хууль, тогтоол, дүрэм, журам, стандартыг баримталж, хариуцлагатай үйлдвэрлэл, уул уурхайг Монгол улсад хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулахын төлөө ажилладаг. Түүнчлэн олон улсын уул уурхайн компаниудын стандарт, зөвлөгөө зөвлөмж, олон улсын сайн туршлагыг үйл ажиллагаандаа тусгадаг. Компанийн байгаль орчны бодлогын хүрээнд байгаль орчны менежментийн системийг боловсруулж, нэвтрүүлж эхэлсэн. Одоогийн байдлаар байгаль орчны чиглэлээр байгууллагын 3-н дотоод журам батлагдсан бөгөөд тэдгээрийг “нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн үйл ажиллагааны хүрээнд дагаж мөрдөж ажиллаж байна.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Говь ресурс девелопмент” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт байрлах нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны явцад байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа цогц байдлаар шийдвэрлэх арга хэмжээ, түүнд згарцуулагдах зардлыг хамруулан тусгасан. Үйлдвэрийн 2026 оны Байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг Монгол улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 9 ба 10 дугаар зүйл ба байгаль орчныг хамгаалах бусад багц хууль болон холбогдох журам, зааврууд болон байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсэн үнэлгээгээр тавьсан шаардлагууд дээр үндэслэн боловсруулсан.

Хүснэгт 7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанар									
1.	Машин механизмын хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Агаарын тоосжилт бууруулах зорилгоор ачиж буулгах талбай болон тээврийн замыг тогтмол услах	Дотоод зам, Тээврийн зам	-	1,200.000	1	1,200.000	3-10 саруудад өдөрт 2 удаа	MNS ISO 4227:2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 4585:2016 “Агаарын чанар.
2.	Машин механизмгаас ялгарах хорт утаа нь агаарын чанарт сөргөөн нөлөөлөх	Ашиглагдаж буй машин техникийг үзлэгт хамруулах, агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Төслийн талбайд ажиллаж буй ММ, ТХ	удаа	25,000	18	450,000	Жилд 1 удаа	

3.	Баяжуулах үйлдвэрийн эргэлтэт бутлуур, зэрэг үйл ажиллагаанаас их хэмжээний тоосжилт, тортог үүсэх	Тоосжилтыг бууруулах шүршигч тоноглол форсунк ашиглах Тоомжилтыг бууруулах хуурай манангийн системийг /dry fog system/ ашиглах Агаарын бохирдол, тоосжилтыг бууруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ төлөвлөн, хэрэгжүүлэх /ОНС /		Үйл ажилгааны зардлаар	Жилд 2 удаа			
4.	Ахуйн хог хаягдлыг шаардлага хангасан нөхцөлд түр хадгалаагүй болон тогтмол төвлөрсөн хог хаягдлын цэг рүү зөөвөрлүүлээгүйн улмаас агаар бохирдох	Хогийг ангилах, зориулалтын хогийн саванд хаяж байх, тогтмол хог хаягдлын төвлөрсөн цэг рүү ачуулж байх	-	Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөөнд тусгав	Тухай бүрт	Техникийн ерөнхий шаардлага” MNS 6063:2010 “Агаарын чанар – Хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ” MNS 5885:2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4990:2000 “ХААЭА. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага”.		
		Хог хаягдлын төвлөрсөн цэгийг стандартын дагуу тохижуулалт хийх	Төслийн талбай	Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөөнд тусгав	6,7 сард			
		Ангилан ялгах хогын савны тоо ширхэгийг нэмэх	Кемп, оффис	Хог хаягдлыг менежментийн төлөвлөгөөнд тусгав	-			
Хөрсөн бүрхэвч								
5.	Шатах тослох материал нефтийн бүтээгдэхүүн	Асгаралт болсон тохиодолд асгарсан материал, бодисыг шилжүүлэн хийх,	Асгаралтын хэрэгслийг нөхөн сэлбэх			2	-	Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйл. Хогийн саванд тавигдах шаардлагад нийцүүлэн ангилах, ачих цуглуулах

	алдагдах асгаралт үүссэнээр хөрсөн бүрхэвч бохирдох	хадгалах зориулалттай сав бэлэн байлгах, бохирдсон хөрс хураах сав бэлтгэх, Хөрс саармагжуулах талбайг стандартын дагуу хийж, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах./ОНС/	шаардлага гарсан тохиодолд буюу жилд 2 удаа	Удаа Ширхэг	500,000		1,000,000 460,000		технологид нийцсэн, ус хуримтлагдах, шүүрэл ялгарахаас Сэргийлсэн байдлаар байгуулах MNS 3297-1991, “Байгаль хамгаалал.Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм Хог хаягдлын тухай хууль
6.		Хөрс бохирдуулагч нүхэн жорлонг буулгаж, ариутгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх /ОНС/	Төслийн талбайд	Үйл ажиллагааны зардлаар					
7.	Хатуу хучилтгүй зам талбайгаар машин техник зорчиход хөрс элэгдэж тоос шороо босох	Машин техникийг маршрутын замаар явахыг хянах, олон салаа зам гаргахгүй байх тэмдэг тэмдэглэгээ байршуулах	Төслийн талбай, Тээврийн зам дагуу	Үйл ажиллагааны зардлаар			-		
8.	Ахуйн хог хаягдлын битүүмжлэл алдагдах зэргээс үүдэн хур тунадас, үерийн	Хог хаягдлыг зориулалтын саванд хадгалж, сумын нэгдсэн хогийн цэгт зөөвөрлөн хаяж байх, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх	кемп, үйлдвэр	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө-нд тусгав.			Сард 1 удаа		MNS 5850-2019, “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
9.		Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт болон шимэрхэг хөрсний гүнийг тогтоож, тогтоосон		Үйл ажиллагааны зардлаар					

	Хөрсөн бүрхэвчийг хөндөж хуулах, дарах, ухах	хэмжээнд хуулж, бүртгэл хөтлөх, хаягжуулах, нөхөн сэргээлтэд ашиглах	-		-	
10.	Септик системийн бүрэн бүтэн байдал алдагдах, хөрс бохирдох	Шингэн хаягдал хаях цооног/септик танк/ дах бохирдлын хэмжээг хянах, сайжруулах, бохирын хэмжээ дүүрсэн цаг тухайд соруулах	-	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээнд тусгасан	-	
Усны нөөц чанар						
11.	Үйлдвэрийн үйл ажиллагаанд усыг урт хугацаанд хэмнэлт, дахин ашиглалтгүй ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учрах	Цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулах, Саарал усны шинжилгээг MNS4943:2015 стандартад нийцүүлэн цэвэрлэж, зам талбайн тоосжилт дарахад ашиглах / ОНС /	Кемп	Үйл ажиллагааны зардалд тусгах	1 удаа	“Усны тухай” хууль, “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS4596:1998, Компанийн дотоод журам
12.	Газрын доорх усыг ашигласнаар усны нөөц хомсдох, нөөцөд хохирол учирч болзошгүй	Ус ашиглах дүгнэлтэд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх	-	Үйл ажиллагааны зардалд тусгах		

13.	Ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус, хог хаягдлыг ил задгай хаях, улмаар хур борооны усаар угаагдсан гүний усыг бохирдуулах	Ахуйн хог хаягдлыг ангилан хаяж, тогтмол тээвэрлүүлэх	Кемп	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгав	Сард 2 удаа	MNS EN 12255-10 : 2012 Бохир ус цэвэрлэх байгууламж. 10-р хэсэг: Аюулгүй ажиллагааны зарчмууд Хог хаягдлын тухай хууль
		Усыг хэмнэлттэй хэрэглэх талаар санамжуудыг байрлуулах	Үйлдвэр, ажилчдын хотхон	Үйл ажиллагааны зардлаар	Сард 1 удаа	
Ургамалан нөмрөг						
14.	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр ургамалн нөмрөг талхлагдах, машин техникээс ялгарах тоос тортог ургамалан нөмрөгийг бүрхэж фотосинтезийг бууруулна.	Олон салаа зам гаргахгүй, тогтсон нэг замаар зорчих, нэмж гарсан салаа замыг хаах арга хэмжээ авах	Тээврийн зам, Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаар		Байгаль Орчин, Аялал Жуулчлалын сайд, Эрүүл Мэндийн сайд, Онцгой Байдлын Ерөнхий Газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалаар баталсан Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
		Тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоо, засвар үйлчилгээг тогтмол хийх	Сард 1 удаа	Үйл ажиллагааны зардлаар	Сард 1 удаа	
15.	Химийн бодисыг импортлон тээвэрлэх тээврийн хэрэгслийн хөдөлгөөний нөлөөллөөр зам дагуух хөрсөн бүрхэвч, ургамалан нөмрөг талхлагдах сөрөг нөлөөтэй	Химийн бодисыг тээвэрлэхдээ шороон замаар 30км/цаг, хатуу хучилттай замаар 60зм/цагийн хурдтай явах	Химийн бодисын тээврийн үед	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан.		Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хууль, Газар хөндөлтийн хяналт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө, Газар хөндөх зөвшөөрөл олгох болон Ховор ургамлыг хамгаалах дотоод журмууд

16.	Ургамлын нөмрөг доройтох, цөлжих	Тэрбум мод тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд Орон нутагтай хамтран ажиллах /ОНС/	-	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгасан			Жилд 1 удаа	
17.	Ургамалан нөмрөг, ховор ургамлууд, нөлөөлөлд өртөж доройтох, дарагдах устах	Ховор, нэн ховор ургамалд үзүүдэх болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлохын тулд ажиглалт судалгаа хийх, мэдээлэл цуглуулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах	-	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан			2 жилд 1 удаа	
Амьтны аймаг								
18.	Амьтад тээврийн хэрэгсэлд дайруулан, үхэж хорогдох эрсдэтэй	Тээвэрлэлтийн замд мал амьтан дайруулахаас сэргийлэн тэмдэг тэмдэглэгээ тавих, жолооч нарт эрсдэлт газруудын байршлыг мэдээлэх, мал амьтан дайрагдсан тохиолдолд авах арга хэмжээний зааварчилгаа өгөх	Химийн бодисын тээврийн үед	1	150,000	300,000	-	“Тал хээр, говь цөлийн бүсийн авто болон төмөр зам дагуу нүүдлийн туруутан амьтдад зориулсан гарц” байгуулах стандарт, Нүүдэллэдэг зүйлүүдийн конвенц, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ, ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт- 6, ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шалгуур-6,
19.	Төслийн талбай түүний ойр орчимд хог хаягдлыг ил задгай цуглуулснаас мал амьтад тэжээл	Хог хаягдлыг ангилан зориулалтын битүү саванд байршуулах, битүүмжлэлийг байнга хянаж шалгах,	-				-	Хог хаягдлын тухай хууль Өмнөговь Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

	хайж ирэх, орогнож хордож болзошгүй	Ган зуд болон байгалийн цаг уурын хүнд нөхцөл үүссэн тохиолдолд зэрлэг амьтдыг хамгаалах Биотехникийн арга хэмжээг зохион байгуулах		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан.				
20.	Хур бороо багатай, ган зудтай үед зэрлэг амьтан үхэж хорогдох	Зэрлэг амьтан асрах, хамгаалах төвийн зураг төсөв боловсруулж, ажлыг эхлүүлэх ажилд орон нутагтай хамтран оролцох /ОНС/	1 жилд 2 удаа, 5 жилд 10 удаа	1,000.0	2	2,000.000		
Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал							5,410.000 төгрөг	

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримт эрхзүйн баримт бичиг
Ургамал хамгаалах, тоосжилтыг бууруулж, гадаад үзэмжийг сайжруулах, тариалсан зүлэгжүүлэлт, суулгацуудыг арчилж, ургалтыг дэмжих услах	Төслийн талбайн 10 хувьтай тэнцэх талбайд (0.8 га) ногоон байгууламж байгуулах	Үр. 1 м2 талбайд 20 гр, 0.2 га талбайд дунджаар 40 кг олон настын үр	Кг	30	24,000	720,000	6-8 р саруудад 1 удаа	Газрын тухай хуулийн 56.6, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д тус тус заасны дагуу
	20кг бордоо шаардагдана	Кемп орчинд			20,000	600,000		

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 ширхэгээс доошгүй мод тарих /ОНС/		Мод тарих байршлыг Аймгийн БО газраас санал авах	Үйл ажиллганы зардалд тусгав				5,10 сард	
Нийт зардал						1,320.000 төгрөг		

БҮЛЭГ 7. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголд төсөл хэрэгжиж буй талбайн ойр орчимд одоогийн байдлаар түүх, соёлын өв олддоогүй бүртгэгдээгүй болно. Хэрэв төсөл хэрэгжих хугацаанд түүх соёлын олдвор олдсон тохиодолд Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр үйл ажиллагааг түр зогсоох арга хэмжээг авч ажиллана. Соёлын өвийг хамгаалах, түүний түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой ажилд орон нутагтай хамтран ажиллана./ОНС/ Түүх соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлэх, дэмжлэг үзүүлэх.

БҮЛЭГ 8. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал,төг	Нийт зардал,төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх							
Аянга цахилгаан	ОБЕГ-ын мэдээ болон цаг агаарын станцын мэдээг тогтмол хянаж үйл ажиллагаанд харгалзан үзэж болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ, дохиог ажилчид, иргэдэд дамжуулан анхааруулга өгч байх	Цаг уурын мэдээнд суурилах	1	Үйл ажиллагааны зардлаар		3-р улиралд	Гамшгаас хамгаалах тухай хууль
Аадар бороо, үер	Гэнэтийн үер, усны аюулаас хамгаалах суваг шуудуу татах,		1	Үйл ажиллагааны зардлаар Үйл ажиллагааны зардлаар		Жил бүр дулааны улиралд	
Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх							
Гал түймэр	Галын аюулын талаар анхааруулга, самбарыг шинээр барьж буй объект бүрд онцлогт тохируулан байрлуулах	Төслийн талбайд	2	Үйл ажиллагааны зардлаар Үйл ажиллагааны зардлаар		2026 онд	Галын аюулгүй байдлын тухай хууль
Шатах тослох материалын асгарал	Ашиглалт тээвэрлэлт, хадгалалт, зэрэгт хяналт тавьж холбогдох журам	Холбогдох журам боловсруулах	1	-	-	-	

	боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай						
Хөдөлмөр хамгааллын дүрэм алдагдаж ажиллагсад хамгаалах хэрэгсэлээ бүрэн ашиглаагүйгээс ажилчдын эрүүл мэнд нөлөөнд өртөх	Ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт зохион байгуулж, ХАБАЭ-н дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих	Нийт ажилтны сургалт, шинэ ажилтаны сургалт	-	-	-	-	MNS:4969:2000
	Ажиллагсадыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах	Бүх ажилчдыг урьдчилан сэргийлэх багц үзлэгт хамруулах	1	Гэрээний дүнгээр		2-р улиралд багтаах	

БҮЛЭГ 9. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1.	Ахуйн хатуу хог хаягдал	Хог хаягдал түр хадгалах цэг орчимд тогтмол ариутгал хийх, их цэвэрлэгээ хийх	кемп, үйлвэр ийн талбай	удаа	50,000	6	300,000	Улиралд 2 удаа	Хог хаягдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга), Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 17 өдрийн А/443 дугаар тушаалын хавсралт Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,
		Хог хаягдлыг ангилан ялгаж, ААН-тай ачиж тээвэрлэх эрх бүхий байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах	кемп	удаа	Гэрээний дүнгээр		Сард 1 удаа		

		Энгийн болон аюултай хог хаягдлын талбайг стандартын дагуу шинээр хийж, ашиглалтад оруулан, тэмдэг, тэмдэглэгээ байршуулах (ОНС) Хогын цэгт салхинд хийсэхээс хамгаалах арга хэмжээ авч бүрхүүл хийх	кемп	удаа	Үйл ажиллагааны зардлаар			3-р улиралд	тээвэрлэх, Дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага MNS 5344 : 2011 стандарт Өмнөговь Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/8 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт: Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам MNS 4978 : 2017 стандарт Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
					-	-	1,000.000	3,4-р улиралд	
2.	Ахуйн шингэн	Ажилчдын хэрэглээнээс гарсан ахуйн шингэн хаягдыг соруулах, бүртгэл хөтлөх	Бохирын танк	удаа	Үйл ажиллагааны зардлаар			Сар бүр	тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах устгах, булшлах журам MNS 4978 : 2017 стандарт Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, Тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам
	хаягдал	Ахуйн шингэн бохир задлах бодис хэрэглэх		литр	40,000	15	600,000	Улирал тутамд	
		Засвар, хяналт үзлэгийн ажлын үеэр хэрэглэсэн тос тосолгооны сав, цэвэрлэгээний бодис, эд анги, дугуй зэрэг аюултай хог хаягдлыг ангилан ялгаж эх үүсвэр дээр түр хадгалах цэг байгуулах, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай гэрээ байгуулан тээвэрлүүлэх, устгуулах	Засварын төв	Тухай бүрт	-	-	-	Өдөр бүр	

3.	Аюултай хог хаягдал	Гэнэтийн осол эрсдэл зэргээс шалтгаалан химийн бодисын сав баглаа боодолд гэмтэл гарсан эсвэл хэрэглээнээс гарсан баллон, савыг тухай бүрт бүртгэлжүүлэн, тогтоосон хугацаанд хадгалах	Төслийн талбайд	Тухай бүрт				сар бүр	
		Аюултай хог хаягдлыг нэр төрөл бүрээр бүртгэн, бүртгэл хөглөх/ ОНС / БОУАӨЯ-нд тайлан өгөх / ОНС / Аюултай хог хаягдлын үүсгэгчийн тайланг холбогдох эрх бүхий байгууллагад хугацаанд нь гаргаж өгөх	Засварын байр	Тухай бүрт				сар бүр 4 улиралд	
							Нийт	1,900.000 төгрөг	

БҮЛЭГ 10. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 11 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал,төг	Нийт зардал,төг	тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын чанарат үзүүлэх нөлөөллийн бууруулах							
1. Агаар дахь органик биш нэгдэл (NO ₂ , SO ₂ - PM 10,2.5 - Нийт тоос)	Баяжуулах үйлдвэрийн талбайд (Нийт 1 цэгт)	Улиралд 1 уда	4	60,000	240,000	4,7,10 саруудад	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0017-2-3-16:1988 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам.
Усан орчинд үзүүлэх нөлөөллийн бууруулах							
2. Физик үзүүлэлтүүд, Химийн үзүүлэлтүүд, Нянгийн бүрэн шинжилгээ, усны стандартад заасан үзүүлэлтүүд	Ажилчдын ус хангамжийн худаг	3-улиралд	Усан орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах	150,000	150,000	1,3,7,10 саруудад	MNS MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Хаягдал ус. Ерөнхий шаардлага
3. Худгийн усны түвшин	Үйлдвэрийн болон ахуйн хэрэглээний худгууд	Сард 1 удаа	12	500,000	600,000		

4.	Ялзмаг, нийт азот, хөрсний урвалын орчин, хөдөлгөөнт фосфор (P2O5), солилцох кали (K2O), хөрсний шингээх цогц, карбонат (CaCO3)	Төслийн талбай орчимд (Нийт 1 цэгт)	3 улиралд	1	500,000	500,000	1,3,7,10 саруудад	MNS 3297:2019 “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх”, MNS 4920:2000 “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”, MNS 2305:1995 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам,	
5.	Механик бүрэлдэхүүн, чулуу, чийг, амь чийг, эзлэхүүн жин		3 удгаар улиралд	1	200,000	200,000	3,7,10 саруудад	MNS 3298:1991 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ	
6.	Хүнд металлын шинжилгээ (Нийт 33 төрлийн элементийн агууламж)		Улиралд 1 удаа	4	100,000	400,000	3,7,10 саруудад		
7.	Нянгийн бохирдол: - (1гр-д)Колититр Cl.perferringens титр	Хог хаягдлын цэгээс							
Ургамалан нөмрөгт үзүүлэх нөлөөллийн бууруулах									
8.	Ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, биомасс тодорхойлох	Төслийн талбай	Ургамал ургалтын хугацаанд	1	1,210.000	1,210.000	7,8 саруудад	-	
Нийт							3,300.000 төгрөг		

БҮЛЭГ 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1.	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилд 1 удаа	Удирдлага, ХАБ	
2.	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Сар бүр, жилд 12 удаа	Байгаль орчны мэргэжилтэн (БОМ)	
3.	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг жилд 3-аас доошгүй удаа зохион байгуулж ажиллах /ОНС/	Үйл ажиллагааны зардалд тусгах	3 жил тутамд буюу	ХАБ БОМ	
4.	Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	1.0 сая ₮	Үйл ажиллагааны зардалд тусгав	Удирдлага, ХАБ	
5.	Шалам тээврийн замын арчилгаа, усалгааг тогтмол хийх/ОНС		Үйл ажиллагааны туршид	БО	Эзэмшил газраас Тавантолгой-гашуун сухайт чиглэлийн авто зам хүртэлх замын арчилгаа, усалгааг тогтмол хийх,- манайх ашигладаггүй талбай

6.	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төлөвлөлтийг сайжруулах, хийх ажлыг тодорхой тусгах, тоо баримт, үндэслэлийг тодорхой оруулах, баримт нотолгоог хавсралтаар бүрэн оруулах ОНС/		Үйл ажиллагааны туршид	БОМ	

БҮЛЭГ 12. ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 13 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам	Цахим	Тухайн жилийн биелэлтийн тайлан	11-р сарын 01-ний дотор	-	БОМ	Цахим
Өмнөговь аймгийн байгаль орчны газар	Тухай жилийн биелэлтийн тайланг албан бичгийн хамт хүргүүлэх		11-р сарын 01-ний дотор	-	БОМ	Өмнөговь аймгийн байгаль орчны газарт
	Орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах, багийн	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг		-		

Цогтцэций сумын ЗДТГ-т	иргэдийн нийтийн хурал болон бусад хурал зөвлөгөөн дээр мэдээлэл хүргэж ажиллах /ОНС/	өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн бичвэр байна. Тухайн ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна.	11-р сарын 01-ний дотор		БОМ	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЗДТГ- т
---------------------------	---	---	----------------------------	--	-----	---

Хүснэгт 14 Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал

№	БОМТ	Тухайн жилийн БОМТ-ний зардал(мян.төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	5,410.0
2	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,900.0
3	Нөхөн сэргээлт	1,320.0
4	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	-
6	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
7	Осол эрдэлийн менежментийн төлөвлөгөө	-
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	3,300.0
9	Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ	-
	Нийт	11,930.0

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ АЖЛЫН ЗАРДАЛ

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн тухай. “Говь Ресурс Девелопмент” ХХК нь Монгол улсын Ашигт малтмалын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай, Усны тухай, Ус рашаан ашигласны төлбөрийн тухай хуулиуд болон бусад хууль, журмын дагуу төлбөр хураамжуудыг тухай бүрд төлж ажиллана. Нүүрс баяжуулах үйлдвэрийн төслийн Байгаль орчныг хамгаалах 2026 оны төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардалд 11,930.000 төгрөг / арван нэгэн сая есөн зуун гучин мянган төгрөг / төлөвлөсөн ба Сангийн Яамны Төрийн санд нээсэн 100900013406 дугаартай дансанд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үүргээ биелүүлэх баталгааны мөнгөн хөрөнгийн 50% болох 5,965.000 төгрөгийг байршуулна.